



ЭРҮҮЛ МЭНДИЙГ
ЦЭНЭГЛЭСЭН 10 ЖИЛ

2022 ОНЫ III ДУГААР УЛИРЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД



ЭХЭМҮТ-ИЙН ЕРӨНХИЙ МЭС ЗАСЛЫН ТАСГИЙН ӨРӨӨГ ТОХИЖУУЛАА

ЭХЭМҮТ-ийн Ерөнхий мэс заслын тасгийн хүлээлгийн болон үзлэгийн өрөөг иж бүрэн тохижуулж хүлээлгэн өглөө. Энэхүү 2 өрөө нь жилдээ 13,000 гаруй хүүхэд өөрийн асран хамгаалагчийнхаа хамт төлөвлөгөөт болон яаралтай мэс заслын өмнөх мэдээгүйжүүлэлтийн үзлэг, эмч нарын зөвлөгөөг авч хүнд болон хөнгөн хагалгааны өмнө ав, ээж асран хамгаалагчийн хамт сэтгэл санаагаа бэлдэх, цагийг өнгөрүүлэх зорилготой өрөө юм.

МФС 2.0 ТӨСЛИЙН НЭЭЛТ БОЛЖ, БАРИЛГЫН АЖЛЫГ ЭХЛҮҮЛЭВ

Монос Хүнс ХК-ийн "МФС 2.0" үйлдвэрийн шав тавих ёслол болж, төслийн нээлтээ хийлээ. Уг төсөл хөтөлбөр нь компанийн бизнесийн ирээдүйгээ тодорхойлох, хөгжлийн дараагийн үе шатад хөтлөх, хуурай, шингэн хүнсний үйлдвэр болон оффисыг нэгтгэх зорилготой.

Төсөл хэрэгжсэнээр үйлдвэрийн хүчин чадал нэмэгдэж халуун, хүйтэн савлагаа болон биологийн идэвхт бүтээгдэхүүний савлагааг нэгэн зэрэг үйлдвэрлэх боломжтой болох юм.



"ЭРҮҮЛ БИЕЙН ТӨЛӨӨ" СУВИЛАА ӨДӨРЛӨГ ЗОХИОН БАЙГУУЛАВ

Нийгмийн хариуцлагын хүрээнд жил бүр ахмадууддаа чиглэсэн ажлууд зохион байгуулдаг бөгөөд энэ жил "Эрүүл биеийн төлөө" уриан дор Өвөржанчивлан, Аржанчивлан болон Задгай цагаан рашаан сувилуудаар амжилттай зохион байгууллаа. Тус арга хэмжээнд нийт 170 гаруй аймагч, ажилтан хамрагдсан бөгөөд нийгэмд тулгамдаад буй өвчлөл, түүнээс хэрхэн урьдчилан сэргийлэх талаар эмч, мэргэжилтнүүд эрүүл мэндийн зөвлөгөө өглөө.



ДЭЛХИЙН ГЕПАТИТЫН ӨДРИЙГ ТОХИОЛДУУЛАН МЭРГЭЖЛИЙН ЭМЧ НАРТ СУРГААТ ОРЛОО

Монос Хүнс ХК жил бүр тус өдрийг тохиолдуулан эрүүл мэндийн байгууллагатай хамтран иргэдэд элэгний өвчлөлөөс хэрхэн урьдчилан сэргийлэх, элэгний өвчлөлд гол хүчин нөлөөлдөг шалтгааны талаар таниулах, мэдээлэх зорилгоор сургалтууд зохион байгуулдаг билээ. Энэ жил Баянзүрх дүүргийн нэгдсэн эмнэлэгтэй хамтран "Элэгний хорт хавдар, түүнээс урьдчилан сэргийлэлт" сэдвийн хүрээнд сургалт амжилттай зохион байгууллаа.



БАЙГАЛЬД ЭЭЛТЭЙ ҮЙЛДВЭРЭЛ

Үйлдвэрийн хэмжээнд байгальд ээлтэй эрчим хүч бага зарцуулдаг LED гэрэлтүүлэг, эрчим хүчний хэмнэлт бүхий А+ ангилалын цахилгаан хэрэгслүүдийг ашигласнаар III улиралд 11%-ийн цахилгаан хэмнэлт хийлээ. Мөн саарал усыг өөрсдийн ахуй хэрэглээндээ тогтмол ашиглан, зарим тохиолдолд үйлдвэрийн орчины ногоон байгууламжийн усалгаанд хэрэглэж усны хэрэглээг 7%-аар хэмнэв.



7-11%

ШИНЭЭР ГАРСАН БОЛОН ШИНЭЧЛЭГДСЭН БҮТЭЭГДЭХҮҮНҮҮД



Чацаргана болон жүржийн хослол бүхий Увдист шүүс нь витаминь өндөр агууламжтайгаас гадна антиоксидант үйлчилгээтэй. Мөн хэрэглэхэд хялбар савлагаатай бөгөөд 2 литр өтгөрүүлсэн шүүс нь 40-50 аяга шүүс болно.



Байгальд ээлтэй ЭНХЖИН | ЭРҮҮЛ МЭНДИЙН ЦАЙ САВЛАГААГАА ШИНЭЧИЛЛЭЭ

Эмийн ургамалтай Энхжин эрүүл мэндийн цайны сав баглаа боодолд ашиглагдаж байгаа гялгар уутны хэрэглээг 90%, цаасны хэрэглээг 42%-аар бууруулан шинэчилсэн савлагаатайгаар зах зээлд амжилттай байршлаа. Ингэснээр бид жилдээ 8 тонн гялгар уут, болон цаасны хог хаягдлыг бууруулах боломжтой болсон юм.



ТӨСЛИЙН ҮЙЛ ЯВЦ



ҮЙЛДВЭРИЙН
БАРИЛГА

15%

85%



ТОНОГ
ТӨХӨӨРӨМЖ



71%

29%



БҮТЭЭГДЭХҮҮН
ХӨГЖҮҮЛЭЛТ




40%

60%




САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ III УЛИРЛЫН ӨССӨН ДҮНГЭЭР:


Борлуулалтын орлого
/сая.төг/




Нийт ашиг
/сая.төг/




Цэвэр ашиг
/сая.төг/




EBITDA
/сая.төг/




Татвар төлөлт
/сая.төг/



Хөрөнгө оруулалт
/сая.төг/



Ажилтны тоо



САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН

Үзүүлэлт /сая.төг/


2021.12.31

2022.09.30

	2021.12.31	2022.09.30
ХӨРӨНГӨ	22,996.0	32,282.0
Эргэлтийн хөрөнгө	9,818.0	19,571.7
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	258.0	604.7
Дансны авлага	2,880.0	4,220.3
Татвар, НДШ – ийн авлага	73.1	45.4
Бусад авлага	49.7	73.8
Бараа материал	5,785.6	6,302.3
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	771.5	8,325.1
Эргэлтийн бус хөрөнгө	13,178.0	12,710.3
Үндсэн хөрөнгө	12,501.3	12,095.1
Биет бус хөрөнгө	591.0	529.5
Бусад эргэлтийн бус хөрөнгө	85.7	85.7
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	22,996.0	32,282.0
Өр төлбөр	8,075.0	15,502.5
Богино хугацаат өр төлбөр	4,651.3	4,926.0
Дансны өглөг	798.4	1,338.4
Цалингийн өглөг	56.1	126.1
Татварын өр	509.0	1,360.6
НДШ – ийн өглөг	16.3	105.3
Богино хугацаат зээл	2,676.1	976.2
Хүүний өглөг	20.8	60.7
Ногдол ашгийн өглөг	0.0	543.8
Урьдчилж орсон орлого	27.8	27.9
Нөөц /өр төлбөр/	153.7	153.7
Бусад богино хугацаат өр төлбөр	393.1	233.4
Урт хугацаат өр төлбөр	3,423.7	10,576.5
Урт хугацаат зээл	3,423.7	10,576.5
Эздийн өмч	14,921.0	16,779.5
Өмч хувьцаат	2,318.2	2,318.2
Нэмж төлөгдсөн капитал	6,835.7	6,835.7
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	451.9	451.9
Хуримтлагдсан ашиг	5,315.2	7,173.6

САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ III УЛИРЛЫН ӨССӨН ДҮНГЭЭР

Санхүүгийн харьцаа үзүүлэлтүүд	2021	2022
Төлбөрийн чадварын шинжилгээ / Liquidity Ratios		
Эргэлтийн харьцаа / Current Ratio	1.4	4.0
Түргэн хөрвөх харьцаа / Quick Ratio	0.8	2.7
Санхүүгийн тогтвортой байдлын шинжилгээ / Leverage Ratios		
Бие даалтын коэффициент / Shareholder Equity ratio	68%	52%
Өрийн харьцаа / Debt ratio	32%	48%
Өр эзний өмчийн харьцаа / Debt-to-Equity	48%	69%
Хөшүүргийн харьцаа/ Debt-to-EBITDA	1.26%	1.96%
Ашигт ажиллагааны шинжилгээ / Profitability ratios		
Нийт ашгийн хувь / Gross profit margin	45.1%	43.4%
Цэвэр ашгийн хувь / Net income margin	10.3%	12.4%
ХТЭХӨАшгийн хувь / EBITDA margin	14.7%	16.3%
Нийт хөрөнгийн өгөөж / Return on Assets - ROA	6.5%	8.3%
Өөрийн хөрөнгийн өгөөж / Return on Equity - ROE	9.5%	15.9%



“Монос хүнс” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 2 дугаар сарын 18-ны өдрийн №27/02 тоот тогтоолоор 2021 оны цэвэр ашгаас нийт 817,700,856 төгрөг буюу нэгж хувьцаанд 2 төгрөгийг хувьцаа эзэмшигчиддээ ногдол ашиг болгон тараахаар шийдвэрлэсэн байна.

Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдрийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдөр болох 2022.03.31-ний өдрөөр тогтоож, ногдол ашгийг 2022 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн “ҮЦТХТ” ТӨХХК-иар дамжуулан хувьцаа эзэмшигчдийн дансанд байршууллаа.

2021 оны цэвэр ашгаас төлөвлөсөн ногдол ашиг нийт

817,700,856 төгрөг буюу нэгж хувьцаанд 2 төгрөгийг хувьцаа

1 2022 оны 9 дүгээр сарын 1-ний өдөр “ҮЦТХТ” ТӨХХК-ийн дансанд ногдол ашиг байршууллаа.

2 “ҮЦТХТ” ТӨХХК Монгол Хөрөнгийн Биржид бүртгэлтэй үнэт цаасны компаниуд дээрх хувьцаа эзэмшигчдийн данс руу шилжүүлэг хийв.

3 Хувьцаа эзэмшигч өөрийн үнэт цаасны компанид хандаж ногдол ашгаа авна.